Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны
01 дүгээр сарын .02.ний өдрийн
16/07. дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо	Хувийн жин
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх		1	0.7	7
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх	0.5	0.5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал	0.5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал	0.5	0.5	5
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал	0.5	0.5	5
Хэсгийн оноо				4	3.7	37
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх *(гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал		1	1	10
Хэсгийн оноо				3	3	30
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал		1	1	10
Хэсгийн оноо				3	3	30
Үнэлгээний нийт оноо, хувь				10	9,7	97

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

Төрийн нарийн бичгийн даргын 2026 оны
01 дүгээр сарын 02-ний өдрийн
1/61/27 дугаар албан бичгийн 2 дугаар хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Нэг.Товч танилцуулга:

Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 2.4. дэх заалтад 40 ба түүнээс цөөн төрийн алба хаагчтай байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороо нь 3 гишүүн, 41-90 бол 5 гишүүн, 91-ээс дээш бол 7 гишүүнтэй байна гэсний дагуу Батлан хамгаалах яамны ёс зүйн дэд хороо нь 7, яамны харьяа 16 байгууллагын ёс зүйн дэд хорооны 70 гишүүн, ЗХЖШ-ын ёс зүйн дэд хороо нь 7, Төрлийн цэргийн командлал, удирдах газар 4 ёс зүйн дэд хороо 18 гишүүн, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын 69 ёс зүйн дэд хорооны 382 гишүүн нийт 91 ёс зүйн дэд хороонд 484 гишүүн ажиллаж байна.

Хоёр:Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар:

Ёс зүйн сургагч багш бэлтгэх сургалтад Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн хуулийн зөвлөх М.Пүрэвсүрэн, Цэргийн төв эмнэлгийн эдийн засагч О.Батзаяа, Цэргийн дүү бүжгийн эрдмийн чуулгын хууль, хөдөлмөр хамгааллын офицер, дэслэгч Ү.Санжаасүрэн нарыг хамруулж, цаашид дотооддоо сургалтыг зохион байгуулах чадавхыг бүрдүүлсэн.

Батлан хамгаалах яамны харьяа аж ахуйн нэгж байгууллагын 15 ажилтан, албан хаагчдыг Удирдлагын академийн дэргэдэх Төрийн албаны сургуулийн "Төрийн албан хаагчдад зориулсан ёс зүйн цахим сургалт"-д хамруулж, Ёс зүйн II түвшний үнэмлэх-6, Ёс зүйн III түвшний үнэмлэх-9 хүн тус тус авсан.

Багшийн хөгжил, Цахим сургалтын төв, Амжилтын танхим сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулсан "Ажлын байрны сэтгэл ханамжийг сайжруулах замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх нь" 5 модуль сургалтад ҮБХИС-ийн 30 гаруй багш хамрагдаж, амжилттай төгссөн. Тус сургалт нь:

1. Хүний зан төлөв
2. Ухамсрын түвшин
3. Сэтгэл хөдлөл чиглүүлэх арга зүй
4. Энерги, мэдрэмжийн менежментийн аргачлал
5. Ажил мэргэжлийн карьер төлөвлөлт зэрэг сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан.

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:

"Сэтгэл зүйн хөдөлгөөнт бүлэг"-үүдийг томилон Монгол Улсын зүүн, баруун бүсэд Зэвсэгт хүчний 232, 327, 338 дугаар ангиуд болон 065 дугаар ангийн 085, 086, 281, 329 дүгээр салбар болон 124 дүгээр ангийн 168 дугаар салбарууд болон Зэвсэгт хүчний 330, 186, 110, 234 дүгээр ангиуд болон 065 дугаар ангийн 322

дугаар салбар зэрэг нийт 40 гаруй анги байгууллагад ажиллан сэтгэл зүйн сургалт, оношилгоо, зөвлөгөө өгсөн.

Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу 2025 оны 04 дүгээр сарын 21-ээс 05 дугаар сарын 01-ны өдрүүдэд Ёс зүйн дэд хороо сургалтын төлөвлөгөө гарган "Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, баримтлах зарчим, харилцаа хандлага" сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан. Сургалтад Батлан хамгаалах яамны харьяа 15 байгууллагын нийт 685 офицер, ахлагч, сонсогч, ажилтан, албан хаагч хамрагдсан. Сургалтыг БХЁЗДХ-ний дарга хурандаа Д.Мөнхбаяр, гишүүн Л.Ганзориг, Монгол Улсын Ёс зүйн хорооны Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хариуцсан референт З.Соёлмаа, ахлах мэргэжилтэн Д.Мөнхжин нар хийсэн.

Орон нутгийн болон Улаанбаатар цэргийн хүрээний нэгтгэл, ангид байгууллагын соёлыг төлөвшүүлэх, ёс зүйн талаарх сургалтыг Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн багш нартай хамтран Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал, удирдах газар, нэгтгэл, ангийн алба хаагчдад 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс 04 дүгээр сарын 09-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газар болон Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хууль эрх зүйн хэлтэс нь Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран дүүргийн Засаг даргын Тамгын газрын 81 албан хаагч 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр "Авлига ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх", "Хувь хүний хөгжлийг дэмжих" сэдэвт сургалтад хамрагдсан.

Мөн Нийслэл, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын офицер, ахлагч нарын сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж, "Төрийн албан хаагчийн ёс зүйн үнэт зүйл" сэдвээр Удирдлагын академийн багш доктор, дэд профессор Т.Аззаяа, "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга П.Булганмаа тус тус лекц орсон.

Монгол Улсын хэмжээнд кибер орчинд гэмт хэрэг үйлдэгдэх нь нэмэгдэж байгаатай холбогдуулан командлалын цэргийн алба хаагчдад цахим орчин дахь ёс зүйн талаар мэдлэг олгох зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын ахлах мөрдөгч цагдаагийн ахмад Б.Мөнхнаранг 2025 оны 07 дугаар сарын 24-ний өдөр урьж "Цахим орчин дахь гэмт хэрэг, цахим мөрийтэй тоглоом" сэдвээр сургалт зохион байгуулсан.

Зэвсэгт хүчний 10 гаруй анги байгууллагын алба хаагч болон хугацаат цэргийн алба хаагчдад "Хос төв" сургалтын багш П.Хулан "Стресс менежмент" сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 18-аас 03 дугаар сарын 07-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Ёс зүйн сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдсан Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын хууль, хөдөлмөр хамгааллын офицер, дэслэгч Ү.Санжаасүрэн "Батлан хамгаалахын сайдын 2025 оны Төрийн албаны сахилга хариуцлагыг чангатгах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 02 дугаар албан даалгавар,Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай

хуулийн хэрэглээ сэдэвт 1 цагийн сургалтыг яамны харьяа 15 байгууллагын албан хаагчдыг хамруулан 2025 оны 10, 11 дүгээр саруудад зохион байгууллаа.

Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын Үндэсний хөгжмийн албаны уран бүтээлчид Хавдар судлалын үндэсний төвийн "Хавдрын эсрэг хөгжмөөр нэгдэцгээе" хөгжим эмчилгээний хөтөлбөрийн хүрээнд ардын сайхан дуу, аялгуугаар эмнэлгийн үйлчлүүлэгчид хийгээд тэдний ар гэрийнхний сонорыг мялааж, сэтгэлийг анагаах эмчилгээ үйлчилгээ үзүүллээ.

АТГ-ын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Ж.Мөнхжаргал "Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа" сэдэвт сургалтыг 2025 оны 09 дүгээр сарын 10-30-ны өдрүүдэд Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 34 алба хаагч, ҮБХИС-ийн Батлан хамгаалахын удирдлагын академид Батлан хамгаалахын сайдын тушаалаар "Нэгтгэл, ангийн захирагчийн дамжаа"-нд суралцаж буй Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн 20 гаруй захирагч нарын дунд зохион байгуулсан.

Ёс зүйн дэд хорооноос Төрлийн цэргийн командлалын цэргийн алба хаагчдыг оролцуулан 1 минут 30 секундийн "Цэргийн алба хаагчийн Ёс зүйн андгай" шторкийг бэлтгэсэн БХЯ, ЗХЖШ, "Дуулга" студийн цахим хуудастуудаар байршуулан олон нийтэд сурталчилсан бөгөөд нийт 29400 хүнд хүрсэн байна.

Мөн алба хаагчдын ёс зүй, харилцаа хандлагад чиглэсэн богино хэмжээний дүрс бичлэг, контент бүтээх төсөл боловсруулж, "Цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг сурталчилсан богино хэмжээний дүрс бичлэгийг бэлтгэн салбарын цахим хуудсаар сурталчилж 17 мянган хүнд хүрээд байна.

"Төрийн алба хаагчийн ёс зүйн нийтлэг зарчим" гэсэн контент бэлтгэн, Ёс зүйн хорооны цахим хуудас, youtube суваг, БХЯ, ЗХЖШ-ын вэб сайтуудад байрлуулсан.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны манлайлал:

Яамны Төрийн нарийн бичгийн дарга нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-д заасны дагуу Батлан хамгаалах яамны Ёс зүйн дэд хороо болон яамны харьяа агентлаг, аж ахуйн нэгж байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүд урамшууллыг олгох тухай зөвлөмж хүргүүлснээр ёс зүйн дэд хороод урамшуулал авч байна.

Батлан хамгаалах салбар удирдах бүрэлдэхүүний цугларалтад Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, ШУА-ийн академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, Чингис хаан одонт С.Нарангэрэлээр "Хүмүүн байхын учир ёс суртахуунд оршвой" сэдвээр лекц сургалт зохион байгуулсан.

2.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Батлан хамгаалахын сайдын 2024 оны А/205 дугаар тушаалаар баталсан "Цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг яамны харьяа аж ахуйн нэгж байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын нийт офицер, ахлагч нарт сурталчлан таниулж, ёс зүйн андгай өргүүлж, гарын үсгээр баталгаажуулах ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 15-30-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Цэргийн албa хаагчдын холбогдсон гэмт хэрэг, ёс зүйн болон бусад зөрчлийн түвшин, хөдөлгөөн, тархалт, шалтгаан нөхцөлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудаас гэмт хэрэг, зөрчлийн судалгаа, мэдээллийг улирал бүр авч, дүн шинжилгээнд суурилсан арга хэмжээг авч хэрэгжүүлж хэвшсэн.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд яамны харьяа аж ахуйн нэгж байгууллага, Зэвсэгт хүчний анги байгууллагын ёс зүйн дэд хороод бие бүрэлдэхүүний ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ёс зүйн дэд хорооны баримт бичгийн самбарыг байршуулан цаг үеийн мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна.

Гарсан үр дүн, ололт амжилт	Бэрхшээл
1.2025 оны жилийн эцсийн байдлаар Батлан хамгаалах яам, харьяа аж ахуйн нэгж, байгууллагуудын Ёс зүйн дэд хороонд ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол ирүүлээгүй байна. (2023 онд 6 зөрчил, 2024 онд 4 зөрчил, 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар зөрчил гараагүй байна.) Албa хаагчдын ёс суртахууны мэдлэг, хандлага, харилцаа сайжирч, байгууллагын дотоод соёлд эерэг нөлөө үзүүлэн ёс зүйн зөрчил, гомдлын тоо жил бүр буурч байна. 2.Эрдэмтэн доктор, профессоруудын оролцоотой сургалт, уулзалтаар албa хаагчдын ёс зүй, харилцаа, хандлагын талаарх ойлголтыг гүнзгийрүүлж, соён гэгээрүүлэх ажлын оролцооны соёл төлөвшиж, ёс зүйн дэд хороодын сургалт, соён гэгээрүүлэх ажил тогтмолжсон. 3.Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн цэргийн сэтгэл зүйчдийн орон тоо өмнөх оноос 12 хувиар нэмэгдсэн нь сэтгэл зүй, ёс суртахууны талаар зөвлөгөө мэдээлэл авах албa хаагчид тогтмол өсөж, сургалт соён гэгээрүүлэх ажлын чанар хүртээмж улам сайжирсан. 4.Цахим нөлөөллийн шторк, контент бэлтгэн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилсан.	-

БАТАЛГААЖУУЛАЛТ:
БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА ХОШУУЧ ГЕНЕРАЛ Д.ГАНХУЯГ

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА ХУРАНДАА Т.МӨНХБАЯР

2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажил зохион байгуулж, гомдол мэдээллийг хянан шийдвэрлэх.

2025 онд хэрэгжүүлэх аян "Ёс зүйтэй харилцаа-Ёс зүйтэй хандлага"

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах албан тушаалтан
1. Үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтын чиглэлээр							
1	Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	75 хувь	90 хувь	жилдээ	Хурандаа Т.Мөнхбаяр Дэд хурандаа Ж.Сэлэнгэ
2	Яамны ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны тайлан Төрийн албаны зөвлөлийн ёс зүйн хороонд хүргүүлэх	-	Тайлангийн тоо	1	2	Хагас бүтэн жил	Хурандаа Т.Мөнхбаяр Дэд хурандаа Ж.Сэлэнгэ
3	Харьяа аж ахуйн нэгж, байгууллагын ёс зүйн дэд хороог үүрэг чиглэлээр хангаж ажиллах, тайлан мэдээг хүлээж авч нэгтгэн, хянах	-	Хүлээн авсан тайлангийн тоо Үүрэг чиглэлээр хангасан байдал	Тайлангийн тоо 2	Тайлангийн тоо-4 Үүрэг чиглэлийн хангасан зөвлөмжийн хэрэгжилтийг 90 хувьд хүргэх	Улирал бүр	Хурандаа Т.Мөнхбаяр Дэд хурандаа Ж.Сэлэнгэ

4	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, яамны цахим хуудсанд мэдээ мэдээллийг тогтмол байршуулах	-	Мэдээллийн тоо	2	6	Улирал бүр	Дэд хурандаа Б.Энхтөвшин Ж.Сэлэнгэ
2. Төрийн албанд ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээ, шударга байдлыг эрхэмлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх чиглэлээр							
5	Төрийн албан хаагч ёс зүйтэй ажиллахад дэмжлэг үзүүлэх сургалт, Ёс зүйтэй харилцаа-Ёс зүйтэй хандлага" нөлөөллийн ажлыг идэвхжүүлэх	2.5 сая	Зохион байгуулсан сургалтын тоо	4	8	Тухай бүр	Хурандаа Т.Мөнхбаяр Энгийн Г.Энхболд Л.Ганзориг Ц.Алтантуяа
6	Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, Цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрмийг сурталчилах ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулах	5.0 сая	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-	3000	Тухай бүр	Хорооны гишүүд
7	Байгууллага төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг ёс зүйн чиглүүлэх сургалтад хамруулж хэвшүүлэх	2.0 сая	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-	2	Тухай бүр	Хурандаа Т.Мөнхбаяр Энгийн Г.Энхболд Л.Ганзориг Ц.Алтантуяа
8	Байгууллагад ёс зүйн хариуцлага хүлээсэн төрийн албан хаагчийг танхимын давтан сургалтад хувийн зардлаар хамруулах	-	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-	2	Тухай бүр	Хурандаа Т.Мөнхбаяр Энгийн Г.Энхболд Л.Ганзориг
9	"Ёс зүйтэй харилцаа-Ёс зүйтэй хандлага" гэсэн нөлөөллийн аяныг хэрэгжүүлэх (богино хэмжээний дүрс бичлэг хийх, зурагт хуудас гэх мэт хийж олон нийтийн сүлжээнд байршуулах)	3.0 сая	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	5	14 хоногт нэг удаа	Тухай бүр	Дэд хурандаа Б.Энхтүвшин Хорооны гишүүд
10	Монгол Улсын Ёс зүйн хороотой хамтран сургалт зохион байгуулах	2.5 сая	Сургалтын тоо	-	4	Тухай бүр	Хорооны гишүүд

3.Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх чиглэлээр							
11	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол мэдээллийг хүлээн авч, бүртгэх, гишүүдэд хуваарилах	-	Хүлээн авсан гомдол мэдээллийн тоо	-	0	Тухай бүр	Хурандаа Т.Мөнхбаяр Дэд хурандаа Ж.Сэлэнгэ
12	Яамны ёс зүйн дэд хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэж, дүгнэлт гаргах	-	Шийдвэрлэсэн гомдлын тоо	1	0	Тухай бүр	Хорооны гишүүд
13	Ёс зүйн дэд хорооны хуралдааны тэмдэглэлийг хөтлөх, шийдвэрийг албажуулах, холбогдох аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх	-	Хуулийн хугацаанд иргэнд хариу хүргүүлсэн байдал	1	0	Тухай бүр	Хурандаа Т.Мөнхбаяр Дэд хурандаа Ж.Сэлэнгэ

ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТАЛСАН:
БАТЛАН ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ХЯНАН ШАЛГАГЧИЙН АЛБАНЫ ДАРГА,
ЯАМНЫ ЁС ЗҮЙН ХОРООНЫ ДАРГА,
ХУРАНДАА Т.МӨНХБАЯР

2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН:
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
ДЭД ХУРАНДАА Ж.СЭЛЭНГЭ

2025 оны 01 дүгээр сарын ...ны өдөр